



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/265

Улаанбаатар хот

Өр барагдуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Багахангайн Мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ-ын “Худалдаа хөгжлийн банк” (Улаанбаатар хотын банк)-ны зээлийн өр төлбөрт шүүхийн шийдвэрийн дагуу битүүмжлэгдсэн үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж, 2 га газрыг чөлөөлж үүссэн өр төлбөрийг барагдуулах, хөрөнгө хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-д үүрэг болгосугай.

2.Өр төлбөрийг барагдуулахад шаардагдах 429,304,650.57 (дөрвөн зуун хорин есөн сая гурван зуун дөрвөн мянга зургаан зуун тавин төгрөг тавин долоон мөнгө) төгрөгийг Нийслэлийн 2025 оны төсөвт тусгагдсан “Шүүхийн шийдвэрийн дагуу иргэн, байгууллагад олгох төлбөр” зардлаас гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т, хянан санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т тус тус зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1725021274



Yes No Don't know
ہاں نہیں ہمارے پاس نہیں

U) .. يتم التخصيص للموظفين في القطاعين الحكومي والخاص من خلال (مخصصات) للموظفين في القطاعين الحكومي والخاص، حيث يتم تخصيص المخصصات للموظفين في القطاعين الحكومي والخاص من خلال (مخصصات) للموظفين في القطاعين الحكومي والخاص ..

Handwritten text in Arabic script, likely a library stamp or title, with a large '2' written vertically over it.

1725020724